

**МОНГОЛ УЛСЫН 2015 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ БОЛОН ХОЛБОГДОХ БУСАД
ХУУЛИЙН ТӨСЛҮҮДИЙН ТАЛААР ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРООНООС ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНД ХҮРГҮҮЛЭХ САНАЛ
ДҮГНЭЛТ**

2014 оны 11 дүгээр
сарын 05-ны өдөр

Улаанбаатар
хот

**Илтгэгч нь: Улсын Их Хурлын
гишүүн Г.Батхүү**

Монгол улсын Засгийн газраас өргөн мэдүүлсэн Монгол улсын 2015 оны төсвийн тухай хуулийн төсөл болон холбогдох бусад хуулийн төслүүдийг Эдийн засгийн байнгын хороо 2014 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн хуралдаанаар хэлэлцлээ.


Байнгын хорооны хэлэлцүүлгийн явцад Ажлын хэсгийн гишүүн Г.Батхүү, Ц.Баярсайхан, Д.Ганбат, Б.Гарамгайбаатар нараас “2015 оны төсвийн төслийн орлогын тооцоог 2015 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2016-2017 оны төсвийн төсөөллийн тухай хуульд заасан хэмжээнд хүргэж, 40 орчим тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэх, Эдийн засаг нийгмийг 2015 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, 2015 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2016-2017 оны төсвийн төсөөллийн тухай хуульд заасан хэмжээгээр эдийн засгийн бодит өсөлт болон төсвийн зарлагын тооцоог дахин хийх, 2015 оны төсвийн төсөлд санхүүжилт нь дутуу тусгагдсан зарим хөрөнгө оруулалтуудын төсөл, арга хэмжээг гүйцээн дуусгахад шаардагдах хөрөнгийг төсвийн ерөнхийлөн захирагчдын багцад нэмж тусгах” санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжлээ.

Мөн Улсын Их Хурлын гишүүн С.Дэмбэрэлийн гаргасан “2015 оны улсын нэгдсэн төсвийг алдагдалгүй байхаар батлах, 2017 онд төлөх Засгийн газрын 500 сая ам.доллар, Засгийн газрын баталгаа бүхий Хөгжлийн банкны 580 сая ам.долларын гадаад өрийг төлөх санхүүгийн эх үүсвэрийг 2015-2016 оны төсвөөс бүрдүүлэх, Хөгжлийн банк, Чингис болон Самурай бондуудын хүүний төлбөрөөс гадна үндсэн өрийн эргэн төлөлттэй холбоотой зардлыг төсвийн зардалд оруулан, төсвийн нийт тэнцлийг тооцдог болох, Импортын татварын хөнгөлөлтүүдийг түр хугацаагаар зогсоох” зэрэг саналууд, Улсын Их Хурлын гишүүн Ц.Нямдоржийн “2015 оны төсвийн урсгал зардал, цалингийн санг 2012 оны түвшинд барих, Төсвийн хэмнэлтийн онцгой горимд шилжих” тухай, Улсын Их Хурлын гишүүн Г.Батхүү, С.Бямбацогт, Д.Ганхуяг, С.Дэмбэрэл, С.Одонтuya нараас гаргасан “2015 оны төсвийн орлогын зохих хэсэгт төрийн болон орон нутгийн өмчйт, төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан хуулийн этгээдийн дамжуулан зээлдүүлсэн төлбөрийн хугацаа хэтэрсэн зээлийг төлүүлж улсын нэгдсэн төсөвт орлогыг оруулах зохицуулалт нэмэх” тухай саналуудыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.12-т заасныг үндэслэн тус Байнгын хороогоор дэмжигдсэн зарчмын зөрүүтэй саналын томьёоллуудыг Байнгын хорооны санал дүгнэлтийн хамт Төсвийн байнгын хороонд хүргүүлэх нь зүйтэй гэж тус Байнгын хороо үзэв.

Байнгын хорооны хуралдаанаар дэмжигдсэн зарчмын зэрүүтэй саналын жагсаалтыг хавсаргав.

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА



Б.ГАРАМГАЙБААТАР

**МОНГОЛ УЛСЫН 2015 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ БОЛОН ХОЛБОГДОХ БУСАД
ХУУЛИЙН ТӨСЛҮҮДИЙН ТАЛААРХ ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ДЭМЖСЭН САНАЛЫН ТОМЬЁОЛОЛ**

1.2015 оны төсвийн төслийн орлогын тооцоог 2015 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2016-2017 оны төсвийн төсөөллийн тухай хуульд заасан хэмжээнд хүргэж, 40 орчим тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэх.

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Г.Батхүү,
Ц.Баярсайхан, Д.Ганбат, Б.Гарамгайбаатар**

2.Эдийн засаг нийгмийг 2015 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, 2015 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2016-2017 оны төсвийн төсөөллийн тухай хуульд заасан хэмжээгээр эдийн засгийн бодит өсөлт болон төсвийн зарлагын тооцоог дахин хийх.

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Г.Батхүү,
Ц.Баярсайхан, Д.Ганбат, Б.Гарамгайбаатар**

3.2015 оны төсвийн төслийн XXIX.1.21-д тусгагдсан томоохон баг суурин газруудыг эрчим хүчээр хангах, сумдын 0.4 кВ-ын өргөтгэл, шинэчлэлтийн ажлыг гүйцээж дуусгах үүднээс төсөл дэх 6,000.0 сая төгрөгийн санхүүжилтүг нэмэгдүүлэн Уул уурхай, эрчим хүчний сайдын 2015 оны төсвийн багцад санхүүжилтүг 12,000.0 сая төгрөг болгож тусгах.

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Г.Батхүү,
Д.Ганбат, Б.Гарамгайбаатар**

4.2015 оны төсвийн төслийн XXIX.1.16-д тусгагдсан 3,000.0 сая төгрөгийн санхүүжилт бүхий Баруун-урт-Асгат-Эрдэнэцагааны 35кВ-ын 197 км цахилгаан дамжуулах агаарын шугам, дэдстанц, 110/35/6 кВ-ын дэд станцын өргөтгөлийн ажлыг гүйцээн дуусгахад шаардагдах 2,400.0 сая төгрөгийн санхүүжилтүг Уул уурхай, эрчим хүчний сайдын 2015 оны төсвийн багцад нэмж тусгах.

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Г.Батхүү,
Д.Ганбат, Б.Гарамгайбаатар**

5.2015 оны төсвийн төслийн XXIX.1.1.1-д тусгагдсан улсын нөөцийн агуулах /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг/ гэснийг өөрчлөн “Замын-үүд дэх Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламжийн автоматжуулалт” ажлын нэрээр сольж төсөвт өртгийг шилжүүлэх. “Монгол улсын 2015 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хавсралт дахь Дорноговь аймагт хэрэгжүүлэх зорилтот хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалтаас “Замын-үүд дэх Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламжийн автоматжуулалт” ажлыг хасах.

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Г.Батхүү,
Д.Ганбат, Б.Гарамгайбаатар**

6. Улаанбаатар-Арвайхээр чиглэлийн 30 км хатуу хүчилттай автозамын их засвар, шинэчлэлтийн санхүүжилт 7,700.0 сая төгрөгийг Зам тээвэр, барилга, хот байгуулалтын сайдын 2015 оны төсвийн багцад нэмж тусгах. /Өвөрхангай, Арвайхээр сум/

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Г.Батхүү,
Д.Ганбат, Б.Гарамгайбаатар**

7. Улаанбаатар-Чойр чиглэлийн 20 км хатуу хүчилттай автозамын их засвар, шинэчлэлтийн санхүүжилт 7,700.0 сая төгрөгийг Зам тээвэр, барилга, хот байгуулалтын сайдын 2015 оны төсвийн багцад нэмж тусгах. /Говьсүмбэр, Сүмбэр сум/

Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Ж.Батсуурь

8. Улаанбаатар-Өндөрхаан чиглэлийн 45 км хатуу хүчилттай автозамын их засвар, шинэчлэлтийн санхүүжилт 11,675.3 сая төгрөгийг Зам тээвэр, барилга, хот байгуулалтын сайдын 2015 оны төсвийн багцад нэмж тусгах. /Хэнтий, Хэрлэн сум/

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Г.Батхүү,
Д.Ганбат, Б.Гарамгайбаатар**

9. Мэдээлэл цуглуулах, тооллого, судалгаа, хяналт шалгалтын ажлыг хөдөө орон нутагт зохион байгуулахад зориулагдсан автомашин худалдан авахад шаардлагатай 750.0 сая төгрөгийн тоног төхөөрөмжийн зардлыг төсвийн төслийн хүрээнд багтаан Үндэсний статистикийн хорооны даргын багцад холбогдох зохицуулалт хийж шийдвэрлэх.

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Г.Батхүү,
Д.Ганбат, Б.Гарамгайбаатар**

10. Дорноговь аймгийн Зүүнбаян-Хатанбулагын 35кВ-ын 180 км цахилгаан дамжуулах агаарын шугамын ажлыг гүйцээн дуусгахад шаардагдах 3,500.0 сая төгрөгийн санхүүжилтиг Уул уурхай, эрчим хүчний сайдын 2015 оны төсвийн багцад нэмж тусгах.

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Ж.Батсуурь,
Ц.Баярсайхан, Л.Энх-Амгалан, Ө.Энхтувшин**

11. Дорноговь аймгийн Замын-Үүд сумыг Замын-Үүдээс Сайншанд чиглэлийн 54.5 км босоо тэнхлэгийн АН-3 авто замтай холбох 4.8 км замын санхүүжилтийг Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайдын 2015 оны төсвийн багцад нэмж тусгах.

Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Ц.Нямдорж

12. 2015 оны улсын нэгдсэн төсвийг алдагдалгүй байхаар, бүр сайжруулбал /+/ тэмдэгтэй байхаар батлах. Үүний тулд урсгал зардлыг дахин төсвийн ерөнхийлөн захирагч бүрээр багасгах, хөрөнгө оруулалтыг а/ хувийн хэвшлийн бизнесийн идэвхжлийг нэмэгдүүлэх б/ үр өгөөж нь 2015 оны эцэст гарах боломжтой обьектуудад чиглүүлэх в/ эрүүл мэнд, боловсрол гэх мэт салбаруудын хөрөнгө оруулалтыг үр ашгийн талаас нь зохистой болгох г/ валютын ханшийн эрэлтийг аль болох бага үүсгэх, инфляцийн дарамт үүсгэхгүй хөрөнгө оруулалтыг сонгох чиглэл баримтлах.

Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн С.Дэмбэрэл

13. 2017 онд төлөх Засгийн газрын 500 сая ам.доллар, Засгийн газрын баталгаа бүхий Хөгжлийн банкны 580 сая ам.долларын гадаад ёрийг төлөх санхүүгийн эх үүсвэрийг 2015-2016 оны төсвөөс бүрдүүлэх. Тухайлбал, 30 хувийг нь 2015 оны улсын

төсвийн хуримтлалаас, 40 хувийг нь 2016 оны улсын төсвөөс тус тус бүрдүүлж, үлдэх 30 хувийг зээлийн эх үүсвэрээр санхүүжүүлэх гэх мэт.

Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн С.Дэмбэрэл

14.Улсын төсвийн хөрөнгө оруулалтыг хувийн хэвшилд шилжүүлэх, улсын төсвийн хэмнэлтийг бий болгох, бизнесийн идэвхжилийг дэмжих зорилгоор төсвийн хөрөнгө оруулалтад хүүний дэмжлэг үзүүлэх механизмыг бий болгох. Үүний тулд зөвхөн хүүний дэмжлэгэд шаардлагатай санхүүгийн эх үүсвэрийг улсын төсөвт төсөвлөдөг байх.

Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн С.Дэмбэрэл

15.2015 оны төсвийн төслийн орлогын өсөлтийн төсөөллийг 2014 оны өсөлтөөс нэмэгдүүлэхгүй байлгах, орлогын өнөөгийн дайчилгаа дээд хэмжээнд байгааг онцгой анхаарах.

Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн С.Дэмбэрэл

16.Төсвөөс гадуур санхүүжүүлж ирсэн Хөгжлийн банк, Чингис бонд, Самурай бонд болон концессийн гэрээгээр гүйцэтгэж буй хөрөнгө оруулалтын төслүүдийн зарцуулалтыг 2015 оноос эхлэн улсын нэгдсэн төсөвт оруулж тооцох.

Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн С.Дэмбэрэл

17.Хөгжлийн банк, Чингис болон Самурай бондуудын хүүний төлбөрөөс гадна үндсэн өрийн эргэн төлөлттэй холбоотой зардлыг төсвийн зардалд оруулан, төсвийн нийт тэнцлийг тооцдог болох.

Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн С.Дэмбэрэл

18.Импортын татварын хөнгөлөлтүүдийг түр хугацаагаар зогсоох, гадаад валютын эрэлтийг бий болгох нелөө бүхий төсвийн зардал (450 тэрбум төгрөг)-ыг бууруулах.

Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн С.Дэмбэрэл

19.Улсын төсвөөр худалдан авах бараа, үйлчилгээг зөвхөн дотоодоос авдаг болох. Энэхүү зохицуулалтыг зөвхөн нэг жил хэрэгжүүлээд зогсоох бус, жил бүрийн төсөв батлахдаа тууштай мөрдлөг болгох.

Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн С.Дэмбэрэл

20.2015 оны төсвийн урсгал зардал, цалингийн санг 2012 оны тувшинд барих. Шинээр ашиглалтад орсон сургууль, цэцэрлэг, эмнэлгийн орон тоог хадгалах замаар хэмнэлтийн онцгой горимд шилжих.

Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Ц.Нямдорж

21.2015 оны төсвийн төслийн хөрөнгө оруулалтын хэсэгт аймгийн төвийн цэвэрлэх байгууламжийн өргөтгөл, шинэчлэлийн санхүүжилт 5,000.0 сая төгрөгийг нэмж тусгах. /Баян-Өлгий, Өлгий сум/

Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн А.Тлейхан, А.Бакей

22.2015 оны төсвийн төслийн хөрөнгө оруулалтын хэсэгт аймгийн төвийн 8 км хатуу хучилттай автозамын их засвар, шинэчлэлийн санхүүжилт 4,500.0 сая төгрөгийг нэмж тусгах. /Баян-Өлгий, Өлгий сум/

Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн А.Тлейхан, А.Бакей

23.Чингэлтэй дүүргийн 3-р хорооны нутаг дэвсгэрт байрлах 19-р цэцэрлэгийн өргөтгөлийн санхүүжилт 1,515,500.0 мянган төгрөгийг Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2015 оны төсвийн багцад нэмж тусгах. /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг/

Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Г.Уянга

24.2015 онд Засгийн газрын авах зээлийн хэмжээг 50 хувь бууруулж, хэмнэгдэх зээлийн үйлчилгээний төлбөр 160 тэрбум төгрөгийг “Хүний хөгжил” сангаас хүүхэд бүрт олгож байгаа 240 тэрбум төгрөг дээр нэмж Монгол улсын хүүхэд бүрт, ахмадууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд сар бүр 30.0 мянган төгрөг олгох.

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт,
А.Тлейхан, Θ.Энхтүвшин**

25.Хөвсгөл аймгийн Мөрөн сумын автозамын шинэчлэлтийн санхүүжилт 11,500.0 сая төгрөгийг Зам тээвэр, барилга, хот байгуулалтын сайдын 2015 оны төсвийн багцад нэмж тусгах.

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Ж.Батсуурь,
С.Бямбацогт, Ц.Нямдорж, А.Тлейхан, Л.Энх-Амгалан, Θ.Энхтүвшин**

26.Хөвсгөл аймгийн Могойн гол-Цэцэрлэг сумын төв хоорондох цахилгаан дамжуулах шугамын 990.0 сая төгрөгийн санхүүжилтүүг Уул уурхай, эрчим хүчний сайдын 2015 оны төсвийн багцад нэмж тусгах.

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Ж.Батсуурь,
С.Бямбацогт, Ц.Нямдорж, А.Тлейхан, Л.Энх-Амгалан, Θ.Энхтүвшин**

27.Хөвсгөл аймгийн Шинэ-Идэр сумын Зүүннуур хүртэлх цахилгаан дамжуулах шугамын 195.0 сая төгрөгийн санхүүжилтүүг Уул уурхай, эрчим хүчний сайдын 2015 оны төсвийн багцад нэмж тусгах.

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Ж.Батсуурь,
С.Бямбацогт, Ц.Нямдорж, А.Тлейхан, Л.Энх-Амгалан, Θ.Энхтүвшин**

28.Хөвсгөл аймгийн Баянзүрх сумын Дэлгэрмөрөн голын гаралтын дүүжин гүүрний санхүүжилт 1,500.0 сая төгрөгийг Зам тээвэр, барилга, хот байгуулалтын сайдын 2015 оны төсвийн багцад нэмж тусгах.

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Ж.Батсуурь,
С.Бямбацогт, Ц.Нямдорж, А.Тлейхан, Л.Энх-Амгалан, Θ.Энхтүвшин**

29.Хөвсгөл аймгийн ИХ-Уул сумын Сэлэнгэ мөрний Дөрөө хангинаурын гаралтын дүүжин гүүрний санхүүжилт 1,500.0 сая төгрөгийг Зам тээвэр, барилга, хот байгуулалтын сайдын 2015 оны төсвийн багцад нэмж тусгах.

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Ж.Батсуурь,
С.Бямбацогт, Ц.Нямдорж, А.Тлейхан, Л.Энх-Амгалан, Θ.Энхтүвшин**

30.2015 оны төсвийн төслийн улсын өрийн нийт хэмжээг төсвийн хүрээний мэдэгдлийн шалгуурт нийцүүлэх.

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Ж.Батсуурь,
С.Бямбацогт, Ц.Нямдорж, А.Тлейхан, Л.Энх-Амгалан, Θ.Энхтүвшин**

31.2015 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2015 оны нэгдсэн төсвийн нийт зарлагын тооцоонд Хөгжлийн банк, Чингис, Самурай бондын орлого, зарлагыг оруулах. Энэ

орлого, зарлагыг 2016-2017 оны төсвийн төсөөллийн тухай хуульд оруулах.

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Г.Батхүү,
Д.Ганхуяг, С.Дэмбэрэл, С.Одонтуяа**

32.2015 оны төсвийн орлогын зохих хэсэгт төрийн болон орон нутгийн өмчit, төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан хуулийн этгээдийн дамжуулан зээлдүүлсэн төлбөрийн хугацаа хэтэрсэн зээлийг төлүүлж улсын нэгдсэн төсөвт орлогыг оруулах зохицуулалт нэмэх.

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Г.Батхүү,
С.Бямбацогт, Д.Ганхуяг, С.Дэмбэрэл, С.Одонтуяа**

33.Дараах компаниудыг татан буулгаж зардал хэмнэх:

- 1.Эрдэнэс МГЛ
- 2.Мон-Атом
- 3.Монголын төмөр зам.

Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Ц.Нямдорж

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРОО